Элэг шилжүүлэн суулгах мэс засалд орсон амьд доноруудын амьдралын чанар ба мэс заслын дараах хугацаа

Ч.Мөнхзаяа[1,2], Д.Даваадорж[1], М.Сугармаа[3,*]

[1]АШУҮИС, Анагаах Ухааны Сургууль
[2]Хавдар Судлалын Үндэсний Төв
[3]АШУҮИС, Нийгмийн Эрүүл Мэндийн Сургууль
Цахим шуудан: mzaya_ch@cancer-center.gov.mn, Утас: 99070980

Түлхүүр үг:

Амьд донор
Биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийн байдал
SF-36

Товч утга: Дэлхийд 2015 оны байдлаар нийт эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын 20 хүртэлх хувийг амьд донороос эрхтэн шилжүүлэн суулгасан байна. **Зорилго:** Элэг шилжүүлэн суулгах мэс засалд орсон амьд донорууудын амьдралын чанарыг урт хугацаанд тодорхойлох. **Арга, аргачлал:** Элэг шилжүүлэн суулгах мэс засалд эрхтэн хандивласан амьд донорууудын амьдралын чанар нөлөөлөх зарим хүчин зүйлийг судлахдаа аналитик судалгааны агшингийн загвараар 2018-2019 оны хооронд Хавдар Судлалын үндэсний төвийг түшиглэн хийж гүйцэтгэсэн. **Үр дүн:** Нийт элэг шилжүүлэн суулгах мэс заслын дараах донорууудын 65.1%-д зовиур илэрч, 52.4%-д мэс заслын дараах ачаалал даах чадвар өөрчлөгдсөн байна. Харин оролцогчдын 8.1%-д мэс заслын дараа ажлын байрны ачаалал нэмэгджээ. **Дүгнэлт:** Нийт элэг шилжүүлэн суулгах мэс заслын дараах донорууудын дийлэнхи хувьд зовиур илэрч, мэс заслын дараах ачаалал даах чадвар өөрчлөгдсөн.

Үндэслэл: Элэг шилжүүлэн суулгах (ЭШС) мэс засал нь элэгний эмгэгийн төгсгөлийн үе шатанд хийгдэх мэс засал юм. 2015 оны байдлаар дэлхийд 34854 орчим хүн эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал хийлгэснээс 6892 нь амьд, 27962 нь амьгүй донороос (цогцосноос) эрхтэн шилжүүлэн суулгасан байна[1]. Монгол улсад 2003-2018 оны хооронд нийт 400 гаруй хүн Монгол, Энэтхэг, Солонгос, Хятад, Сингапур, Япон, Гонконг зэрэг орнуудад амьд донороос элэг шилжүүлэн суулгах мэс засал хийлгэжээ[2]. Амьдралын чанар нь хувь хүний бие махбодийн эрүүл мэнд, сэтгэл санааны байдал, хараат бус байдлын түвшин, нийгмийн харилцаа мөн хүрээлэн буй орчны юмс үзэгдэлтэй харьцаж буй байдал зэргээр тодорхойлогдох өргөн хүрээний ойлголт юм[3]. Эрхтэний донор болон элэг хандивлах мэс засалд орсон хүмүүст мэс заслын дараах амьдралын чанар, түүний өөрчлөлтийг удаан хугацаанд судлах шаардлагатай байна. Энэ нь ирээдүйд эрхтэний доноруудын хэрэгцээ шаардлагад тохирсон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болон нийгэм-сэтгэл зүй, эдийн засгийн хүртээмж сайжрахад түлхэц болох юм.

Зорилго: Элэг шилжүүлэн суулгах мэс засалд орсон амьд донорууудын амьдралын чанарыг урт хугацаанд тодорхойлох.

Зорилт:

1. Элэг шилжүүлэн суулгах мэс засалд эрхтэн хандивласан донорууудын бие, сэтгэцийн эрүүл мэнд, амьдралын чанар тодорхойлох
2. Элэг шилжүүлэн суулгах мэс засалд эрхтэн хандивласан амьд донорууудын амьдралын чанарт нөлөөлөх зарим хүчин зүйлсийг тодорхойлох

Арга, аргачлал: *Түүвэр ба хамрах хүрээ:* Аналитик судалгааны агшингийн загвараар 2018 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс 2019 оны 05 дугаар сарын 15-ны хооронд Хавдар Судлалын үндэсний төвийг түшиглэн хийж гүйцэтгэсэн. Бид судалгаанд Хавдар Судлалын Үндэсний Төв (ХСҮТ)-ийн эрхтэн шилжүүлэн суулгах төв, гадаад улсад “Амьд Донороос Элэг Шилжүүлэн Суулгах (АДЭШС)” мэс засалд орж 6 сар ба түүнээс дээш хугацаагаар хяналтад байгаа

судалгаанд оролцохыг зөвшөөрсөн, мэдээлэл бүрэн өгөх боломжтой 63 реципиентийн донорыг магадлалт бус зорилтот түүврийн аргаар судалгаанд хамруулав. Амьд донороос элэг шилжүүлэн суулгах мэс заслын донорын амьдралын чанарыг олон улсын стандарт “SF-36” асуумжаар үнэлсэн. Тус асуумж нь биеийн ба сэтгэцийн эрүүл мэндийг үнэлэх 2 үндсэн 2 бүлэг, 8 дэд бүлэгтэй 36 асуултаас бүрддэг. Асуулт тус бүрийн оноог 1-5 оноогоор үнэлж, бүлэг бүрийн нийлбэр оноог тооцно. Бүлэг тус бүрийн оноог Z оноонд хувиргаж, Z оноог стандартчилсан Т оноонд хувиргана. Т онооны стандартыг олон улсад нийт хүн амын дундах амьдралын чанарын судалгаагаар тогтоосон байдаг. Статистик боловсруулалтыг IBM SPSS 26.0 програмыг ашиглан хийж гүйцэтгэсэн.

Үр дүн: Судалгаандаа элэг шилжүүлэн суулгах мэс засал эмчилгээнд орсон 19-52 настай 63 донорыг хамруулсан. Нийт донорын 71.4% (n=45) хотод оршин суудаг, дундаж нас нь 31.0±7.1, 55.6% (n=35) нь эрэгтэй байсан бөгөөд 38.1% (n=24) бага ба дунд боловсролтой оролцогч байв (Хүснэгт 1). Нийт элэг шилжүүлэн суулгах мэс заслын дараах доноруудын 65.1%-д зовиур илэрч, 52.4%-д мэс заслын дараах ачаалал даах чадвар өөрчлөгдсөн байна. Харин оролцогчдын 8.1%-д мэс заслын дараа ажлын байрны ачаалал нэмэгджээ.

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Үзүүлэлт		Тоо	Хувь
Харьяалал			
	Хот	45	71.4
	Хөдөө	18	28.6
Хүйс			
	Эрэгтэй	35	55.6
	Эмэгтэй	28	44.4
Боловсрол			
	Бага	2	3.2
	Дунд	22	34.9
	Дээд	39	61.9
Нас, дундаж (сх)		31.0	7.1
Нийт		63	100.0

Элэг шилжүүлэн суулгах мэс заслын дараах доноруудын амьдралын чанарын 8 үзүүлэлтээс сэтгэл хөдлөл (RE), бие махбодын үүрэг (RP)-ийн оноо 50-аас доош үнэлгээтэй байв. Бусад 6 үзүүлэлтийн оноо 50-аас дээш үзүүлэлттэй байв (Зураг 1).

Элэг шилжүүлэн суулгах мэс засалд орсоны дараах эхний, дөрөв дэх, долоо дахь мөн найм дахь жилүүдэд донорын сэтгэцийн эрүүл мэндийн оноо 50-иас доош үнэлэгдсэн. Харин ЭШС мэс заслын дараах 8 дахь жилд донорын биеийн эрүүл мэндийн оноо 50-иас бага бусад жилүүдэд харьцангуй тогтвортой 50-иас дээш үнэлэгдсэн (Зураг 2).



Зураг 1. Элэг шилжүүлэн суулгах мэс заслын дараах донорын амьдралын чанар стандартчилсан Т оноо (SF-36)





Зураг 2. Элэг шилжүүлэн суулгах мэс заслын дараах донорын сэтгэцийн болон биеийн эрүүл мэндийн байдлын оноо, жилээр,
А. Сэтгэцийн эрүүл мэндийн байдал ба амьдралын чанар,
Б. Биеийн эрүүл мэндийн байдал ба амьдралын чанар

Хэлцэмж: Бид энэхүү судалгаагаар элэг шилжүүлэн суулгах мэс засалд эрхтэн хандивласан амьд доноруудын амьдралын чанарыг 1-6 жилийн хугацаанд тодорхойлсон. Broering DC нарын 2004 онд хийгдсэн судалгаанд 165 донор хамарагдсан бөгөөд донорын дундаж нас 32 байсан нь манай судалгааны үр дүнтэй ойролцоо байна[6]. 2015 онд АНУ хийгдсэн 127 амьд

донорын SF-36 амьдралын чанарын судалгаанд 2-5, 5-10 жилийн хугацаанд, амьдаралын чанарын үзүүлэлт хяналтын бүлгээс дээгүүр амьдралын чанарын үзүүлэлттэй үнэлэгдэв[4]. Түүнчлэн 2012-2014 онд Пакистан улсад АДЭШС мэс засалд орсон 96 донорууудын дунд хийгдсэн SF-36 амьдралын чанарын судалгаанд биеийн болон сэтгэл зүйн үнэлгээ өндөр гарсан байсан нь уг судалгааны үр дүнтэй нийцэж байна[5].

Дүгнэлт:

1. Элэг шилжүүлэн суулгах мэс заслын амьд донорууудын амьдралын чанарыг 8 дэд бүлэгтэй "SF36" асуумжаар үнэлсэн. Тэдгээрээс сэтгэл хөдлөл ба бие махбодтой холбоотой амьдралын чанарын бүлгийн оноо нь эрүүл хүн амд стандартчилсан дунджаас бага байв. Харин амьдралын чанарыг үнэлэх асуумжийн дээрх 2 бүлэгээс бусад 8 бүлэг нь эрүүл хүн амд стандарчилсан дундажтай ижил байна.
2. Мэс заслын дараах эхний нэг жил болон 6-аас дээш жилийн хугацаанд донорын амьдралын чанарын хувьд биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийн байдлын үнэлгээ буурах хандлагатай байна.
3. Нийт элэг шилжүүлэн суулгах мэс заслын дараах донорууудын дийлэнхи хувьд зовиур илэрч, мэс заслын дараах ачаалал даах чадвар өөрчлөгдсөн.

Ном зүй:

1. *GODT. GLOBAL OBSERVATORY ON DONATION AND TRANSPLANTATION 2016. 2016, 2021.September.13;*
2. *УНТЭ. Элэгний эмгэг-урхаг хүндрэл, оношилгоо эмчилгээний менежмент, хуудас 32. 2015;*
3. *WHO. Measuring quality of life GENEVA 1998, 2021.September.10;*
4. *Janik MK, Księżopolska A, Kostrzewa K, Kobryń K, Moskwa M, Raszeja-Wyszomirska J, et al. Long-Term Health-Related Quality of Life in Living Liver Donors. Ann Transplant [Internet]. 2019 Jan 22;24:45–51. Available from: https://pubmed.ncbi.nlm.nih.gov/30666044*
5. *Humphreville VR, Radosevich DM, Humar A, Payne WD, Kandaswamy R, Lake JR, et al. Longterm health-related quality of life after living liver donation. Liver Transplant Off Publ Am Assoc Study Liver Dis Int Liver Transplant Soc. 2016 Jan;22(1):53–62.*
6. *Broering DC, Wilms C, Bok P, Fischer L, Mueller L, Hillert C, et al. Evolution of donor morbidity in living related liver transplantation: a single-center analysis of 165 cases. Ann Surg [Internet]. 2004 Dec;240(6):1013–26. Available from: https://pubmed.ncbi.nlm.nih.gov/15570207*

Quality of life and the postoperative duration in living donor liver transplant surgery

Munkhzaya Ch[1,2], Davaadorj D[1], Sugarmaa M[3],

[1]MNUMS, School of medicine
[2]National cancer center
[3]MNUMS, School of public health
E-mail: mzaya_ch@cancer-center.gov.mn, Tel: +976 99070980

Introduction: In worldwide, a living donor transplant accounts for 20 percent of total organ transplant in year of 2015. It is required for evaluating long term quality of life and its' change among donors operating on liver transplant.
Materials and Methods: We used cross sectional study design to study some risk factors contributing to quality of life among living liver donors. The study had conducted between 2018 and 2019 year at National Cancer Center of Mongolia. The SF-36 health survey was used to assess quality of life of living liver donors.
Results: The 55.6% (n=35) were men, and mean age of study participants was 31.0±7.1 years.
Conclusion: There has decreasing trend of mental and physical health score during the first one year and after six years of liver transplant surgery.

Keywords: SF-36, living donors, mental health, physical health